

2011 Global Action Week: THE “BIG STORY” LESSON PLAN
“It’s a right, make it right! Education for Girls and Women NOW!”

2011 Даян Дэлхийн Долоо хоногийн Санаачлага: “Нэгэн түүхээс үүдэх сургамж” хичээлийн хөтөлбөр

Нэгдсэн Үндэстний Зүүн Ази Номхон Далайн Охидын Боловсрол Санаачлагаас “Нэгэн түүхээс үүдэх сургамж” сэдэвт долоо хоногийн арга хэмжээг “Global Campaign for Education” байгууллагатай хамтран энэ оны тавдугаар сарын 2-8 ний өдрүүдэд зохион байгуулах гэж байгаа бөгөөд Танай сургуулийг энэ арга хэмжээнд оролцохыг уриалж байна. Дэлхийн 100 гаруй орны хэдэн сая гаруй хүүхэд болон насанд хүрэгчид энэхүү арга хэмжээнд оролцох юм. Танай сургууль “Нэгэн түүхээс үүдэх сургамж” хичээлд идэвхитэй оролцоно гэдэгт итгэж байна.

“Нэгэн түүхээс үүдэх сургамж” нь охид, эмэгтэйчүүд боловсрол эзэмшихийн ач холбогдлын тухай өгүүлэх юм. Охид, эмэгтэйчүүд бичиг үсэг тайлагдаагүй учир нь тэд хэзээ ч сургуульд явж үзээгүй, зарим нь төлбөр хураамжаас болоод сургууль завсарддаг. Боловсролын салбарт хүйсийн тэнцвэрт байдлыг хангах талаар улс гүрний удирдагч нарын өгсөн амлалт 2011 онд хэрэгжнэ гэдэгт найдаж байна.

Танай сургуулийн багш, сурагчид Ази Номхон далайн бүс нутгийн бусад сая сая хүүхдүүдийн нэгэн адил энэхүү арга хэмжээнд нэгдэн орох боломжтой.

Энэхүү арга хэмжээнд зориулж бид зарим нэг материал бэлдсэн болно. Үүнд:

- “Нэгэн түүхээс үүдэх сургамж” хичээлийн хөтөлбөр
- 2011 оны гар зургийн уралдаанд оролцох заавар

Энэхүү арга хэмжээнд оролцсоноор охид, эмэгтэйчүүдэд боловсрол эзэмших боломж олгох юм.

Хүндэтгэсэн,

2011 Global Action Week: THE “BIG STORY” LESSON PLAN
“It’s a right, make it right! Education for Girls and Women NOW!”

2011 Даян Дэлхийн Долоо хоногийн Санаачлага: “Нэгэн түүхээс үүдэх сургамж” хичээлийн хөтөлбөр

ЗОРИЛГО

1. Олон сая хүүхэд болон насанд хүрэгчид сургуульд явж үзээгүй ийнхүү боломж байхгүй бөгөөд эдгээрийн дийлэнхи нь охид, эмэгтэйчүүд байдаг тухай ярилцах
2. Энэ асуудалд зохих анхаарал хандуулах, сурагчдыг аливаа асуудалд жендерийн өнцгөөс хандах чиг баримжаа олгох, хөхиүлэн дэмжих
3. Дэлхийн улс гүрний удирдагч нарын хүйсийн тэнцвэрт байдлыг хангах талаар өгсөн амлалтуудыг эргэн санах, нэхэн асуух
4. Дэлхий нийтийн зүгээс жендерийн тэгш байдлыг хангах чиглэлд авч буй арга хэмжээ санаачлагын бүрэлдэхүүн хэсэг нь болох, оюутан сурагчид өөрсдийн дуу хоолойгоо хүргэх

Хүчээлийн үр дүнд дараахь зүйлд суралцсан байна

- Охидод боловсрол эзэмшүүлснээр гарах ач тус, өгөөжийн талаар тодорхой ойлголттой болох
- Дэлхийн бусад өнцөгт байгаа хүүхэд багачуудын амьдрал ахуйн талаар илүү мэдэж авах
- Охид багачууд сургуульд хамрагдахад учирдаг саад бэрхшээл хийгээд тус нэмэр болдог хүчин зүйлсийн талаар мэдэж авах

А – БҮЛЭГ

А ХЭСЭГ: ТАНИЛЦУУЛГА /5 минут/

Огт боловсролгүй олон сая охид, эмэгтэйчүүдтэй эв санааны нэгдэлээ илрэхийлэх зорилгоор дэлхий нийтийн хүүхэд багачууд зарим нэг гарамгай эмэгтэйчүүдийн хамтаар “Нэгэн түүхээс үүдэх сургамж” аянд нэгдсэн тухай багш нь оюутан сурагчидаддаа тайлбарлаж өгөх.

Багш нь сурагчидаас хэдэн хүн сургууль завсардсан тухай тэдний хэд нь охид эмэгтэйчүүд болохыг асууна. Багш нь дараахи баримт үзүүлэлтийг хэлж өгнө:

- Дэлхий нийтээр 72 сая орчим хүүхэд сургуульд хамрагдаагүй
- Түүнээс 54 хувь нь буюу 39 сая нь охид
- Бичиг үсэг мэдэхгүй 3 хүн тутмын 2 нь эмэгтэйчүүд

Боловсрол эзэмшээгүй охид голдуу:

- Эрт гэрлэдаг
- Хүүхдүүд нь тэжээлийн дутагдал, өвчний улмаас эндэх нь элбэг
- Ядуу байдаг

Зарим нэг гарамгай эмэгтэйчүүдийн тухай мэдэх эсэхийг сурагчдаас асуух, тэд сургууль явж байсан эсэхийг нь лавлах.

Б ХЭСЭГ – ЖЕНДЕРИЙН ОРОЛЦОО БА БОЛОВСРОЛ

Охид болон хөвгүүд хоорондын ялгааг ихэсгэх замаар сурах орчинд нь сөрөг нөлөө үзүүлдэг тодорхой нөхцөл байдлын талаар багш нь сурагчдаасаа асуух.

Хөгжиж буй орнууд дахь эмэгтэйчүүдэд боловсролын гүйцэтгэх үүрэг ач холбогдлын талаар асуух.

(Ахлах ангийн сурагчидтай НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийн талаар ярилцах.) Товчлол:

- НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенцийг 1989 оноос дагаж мөрдөх болсон бөгөөд хүний эрхийн салбар заавал дагах үүрэг бүхий анхны баримт бичиг нь юм.
- Оршин суугаа газар, үндэстэн ястан, шашин шүтлэгээс үл хамааран хүүхэд нэг бүр эдлэх ёстой хүний үндсэн эрхийг тусгаж өгсөн. Эдгээр нь: амьд явах эрх; өв тэгш өсөн хүмүүжих эрх; гадуурхагдаж мөлжин дарамтлуулахгүй байх эрх; гэр бүлийн нийгэм болон соёлын амьдралд өв тэгш бүрэн дүүрэн оролцох эрх.
- Одоогийн байдлаар тус Конвенцид 194 орон нэгдэн орсон нь Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөх хэмжээнд ирсэн
- Ийнхүү Конвенцид нэгдэн орсноор улс орны Засгийн газрууд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүүхдийн эрхийг хамгаалах үүрэг, амлалтыг өөртөө авч байгаа юм.

Ядуу болон нэн ядуу орнууд, тэдгээрийн газар зүйн байршил, тэнд хүүхдүүдийн амьдрах орчин ямар байгаа талаар багш нь сурагчиддаа ярьж өгөх.

Боловсролын салбарт эмэгтэй ба эрэгтэй хүнд эрх тэгш боломжийг хангахад ямар арга хэмжээ авч болох тухай багш нь сурагчдаасаа асуух.

Багш нь сурагчдаасаа тодорхой нэг мэргэжлийг нэрлүүлээд тэдгээрийг голдуу эрэгтэй хүн хийдэг үү эмэгтэй хүн хийдэг үү гэдгийг лавлаж асуух.

Гэртээ ямар ажил хийдэгийг нь сурагчдаас асуух, голдуу эрэгтэй хүн хийдэг /голдуу эмэгтэй хүн хийдэг/ гэрийн ажил байдаг эсэхийг асуух. Ийнхүү эрэгтэй/эмэгтэй гэж хувиарласан нь хэр шударга болох талаар асуух.

Гэрт хийх ар гэрийн ажил дэндүү их тул та нарыг сургуульд явуулахаа болилоо гэж эцэг эх нь хэлбэл хүүхдүүд хэрхэн хүлээж авах тухай асуух.

Сургуульд явах яагаад чухал байдаг тухай асуух, зарим тохиолдолд хүүхдүүд яагаад сургуульд завсарддаг тухай /ялангуяа охид/ саналыг нь асуух.

Үүнд дараахь хариултууд байж болох юм:

- Зарим хүүхдүүд дайн бүхий орчинд амьдардаг, нэг бол тэд байгаль цаг уурын бэрхшээл бүхий газар оршин суудаг учраас
- Боловсролын төсөв бага учир хөвгүүдийн боловсролд илүү анхаарал тавьдаг
- Охид эрт гэрлэсний улмаар сургуулиа орхихоос өөр аргагүй болдог учир нь гэрийн ажилд цаг зав зориулах хэрэгтэй
- Зарим хүүхдүүд сургуулиасаа дэндүүд хол амьдардаг учир гэртээ байх нь илүү аюулгүй. Энэ тохиолдолд охид тэр тусмаа гэмт хэргийн золиос болох магадлал ихтэй
- Ядуурал: зарим хүүхдүүд сургуулиа орхиод хүүхдийн хөдөлмөр эрхэлж гэртээ дэмжлэг үзүүлдэг
- Зарим хүүхэд ном, дэмтэр, цүнх авах мөнгө байхгүй
- Зарим нь сургуулийн төлбөр төлөх чадваргүй
- Зарим газар сурах байр хүрэлцээ муутай
- Зарим газар заах багш байхгүй

В ХЭСЭГ. ЭНЭ БҮХНИЙГ ЯАЖ ӨӨРЧЛӨХ ВЭ (10минут)

Охид сургуульд өргөнөөр хамрагдахад ямар арга хэмжээ авч болох талаар багш нь сургачидаасаа асууна. Үүнд дараахь хариултыг өгч болох юм:

- Хөгжиж байгаа оронд Засгийн газраас охидын боловсролд зориулан дэмжлэг үзүүлэх
- Эрүүл ахуй, ариун цэврийн өрөөг тусад нь тохижуулж өгөх
- Охид ичимхий, сул, дорой гэсэн буруу хэвшлийг арилгах
- Сургуулийн төлбөр, хураамж хийгээд бусад далд төлбөрийг үгүй хийх
- Хөвгүүд, эрчүүд нь охид болон эмэгтэйчүүдийн боловсролыг дэмжигч нь байх

Багш сурагчдаас дараах асуултуудыг асууна. Энэ асуултыг улс төрч хүнд бас хаяглаж болно.

- Дэлхий дээр хэдэн хүүхэд сургууль завсардсан бэ
- Боловсролын салбарт аль бүлэг хамгийн эмзэг вэ
- Боловсролтой нэр алдарт хүрсэн эмэгтэйг нэрлэнэ үү
- Боловсрол яагаад чухал болох талаар зарим нэг үндэслэл хэлнэ үү
- Охид, хөвгүүдийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ

Г ХЭСЭГ. АРГА ХЭМЖЭЭ 30 минут

Охидод боловсрол эзэмшүүлэхийн чухалыг сурагчид асуух. Сурагчид “Охидын боловсрол та бидэнд хэрхэн их тустай вэ?” гэсэн сэдвийг зургаар дүрслэн илэрхийлэх.

Гар зургийн уралдааны болзолыг хавсралтаас үзэж танилцах. /Гар зургийн уралдаанд сайн дурын үндсэн дээр оролцно. Сурагчид өөрсдийн зурсан зургаа гар зургийн тэмцээнд заавал илгээх шаардлагагүй/

Зарим нэг боломжит хариултууд:

- Боловсролтой охин том болоод боловсролтой эмэгтэй болно, улмаар эрүүл чийрэг, эдийн засгийн хувьд бие даасан иймд үр хүүхдүүд нь сургуульд явах магадлал тэр хэмжээгээр өндөр байна
- Боловсролтой эмэгтэй өөрийн болон гэр бүл, үр хүүхдийн эрүүл мэндэд илүү анхаарал тавьдаг
- Эрт гэрлэх явдаг багасч түүнчлэн ДОХ тусах магадлал бага байна.

Багш сурагчидаас асууна: хэрвээ охид сургуульд явдаггүй байсан бол тэдний амьдрал ямар байх бол.

- Багш 2-3 сургачаас огт боловсрол эзэмшээгүйн үр дагавар ямар байх талаар саналыг нь асууна.

Багш боловсрол эзэмшихийн ач тусын талаар, охид мөн нэг адил, зарим нэг жишээ хэлнэ.

Тухайлбал:

- Боловсролтой хүмүүс эрүүл байна учир нь тэд эрүүл аж төрнө, эрүүл мэндтэй холбоотой мэдээ тогтмол уншина
- Боловсрол өлсгөлөнг дийлнэ. Боловсролтой эмэгтэй үр хүүхэд нь өсөглөн тэжээллэг байх магадлал өндөр
- Боловсрол хүний амь аварна. Боловсролтой эмэгтэйгээс гарсан хүүхэд 5 нас хүртлээ эндэхгүй байх магадлал 2 дахин их.
- Боловсрол ядуурлыг дийлнэ.

Багш сургачидаас асууна: бүх охид, эмэгтэйчүүд сургуульд ижил тэгш хамрагдаж чадахгүй байгаа нь шудрага уу.

Гар зургийн уралдаан 2011

“Охидын боловсрол та бидэнд хэрхэн их тустай вэ?”

Нэгдсэн Үндэстний “Охидын Боловсрол Санаачлага”-ын түнш байгууллагуудаас (Ази ба Номхон Далайн бүс нутаг) боловсрол дахь жендерийн тэгш байдлыг дэмжих зорилгоор 3 дахь удаагийн сонгон шалгаруулалтад урьж байна.

Энэ жилийн гар зургийн уралдаан нь “Охидын боловсрол та бидэнд хэрхэн их тустай вэ?” гэсэн сэдвийг дүрслэн илэрхийлсэн байна.

Шалгаруулалт

- Нийт 13 бүтээлийг шалгаруулж “Боловсрол дахь жендер” 2012 оны зурагт хуанлийд хэвлэж Ази – Номхон Далайн бүс нутгаар түгээнэ.
- Шалгарсан бүтээлийн эздэд гэрчилгээ олгоно
- Уралдаан зохион байгуулагч байгууллага нь шалгарсан бүтээлүүдийг өөрийн вэб дээр байрлуулна. Шалгарсан болон уралдаанд ирүүлсэн бусад бүтээлүүдийг нийтэд зориулсан танилцуулга, ухуулга сурталчилгааны зорилгоор уралдаан зохион байгуулагч байгууллага болон Нэгдсэн Үндэстний “Охидын Боловсрол Санаачлага”-ын түнш байгууллагуудын зүгээс хэвлэн нийтлэх, түгээн тараах зэргээр ашиглах болно.

Уралдаанд ирүүлэх бүтээлд тавих шаардлага

- Цаасны хэмжээ нь А4 формат, зургийн ямар ч хэрэгслээр зурж болно. Үүнд өнгийн болон тосон харандаа, усан болон тосон будаг, гуашь г.м
- Зураг нь өнгөт болон хар цагаан байж болно
- Зураг нь, жишээлбэл: *сургуулийн орчин, гэр бүл, спортын наадам* зэрэг ямар ч орчинг дүрслэн илэрхийлж болно.

Зохиогчийн эрх

- Уралдаанд оролцогч нь өөрийн бүтээлийг ирүүлснээр түүнийг үнэ төлбөргүй хуулбарлах, нийтлэх, нийтийн хүртээл болгох, дахин боловсруулах эрхийг энэхүү уралдааныг зохион байгуулагч байгууллага болон Нэгдсэн Үндэстний “Охидын Боловсрол Санаачлага”-ын түнш байгууллагуудад шилжүүлэх бөгөөд ийнхүү ашиглах бүрт зохиогчийн *овог нэр, нас* болон *улсын харьяаллыг* заавал дурьдсан байна.

Хэн оролцож болох вэ

- Ази Номхон далайн бүс нутгийн аль ч улсын иргэнд нээлттэй

- Уралдаанд оролцогч нь 18 ба түүнээс доош настай байна
- Охид, хөвгүүдийг өргөнөөр оролцохыг уриалж байна

Ирүүлэх бүтээлийн тоо

- Нэг болон түүнээс дээш тооны бүтээлээр оролцож болно

Бүтээлээ хэрхэн илгээх вэ

- Хавсралт бүртгэлийн маягыг бөглөнө үү. Зураг нэг бүрийн ард зохиогчийн овог нэр, нас, хүйс болон аль улсын харьяат болохыг **АНГЛИ** хэл дээр тодорхой бичсэн байна.

Бүтээлээ ирүүлснээр зохиогч нь өөрийн нэр, нас болон аль улсын харьяатаа болох тухай мэдээллийг Нэгдсэн Үндэстний “Охидын Боловсрол Санаачлага”-ын вэб хуудас болон бусад хэвлэлд дурьдахыг зөвшөөрсөнд тооцно. Уралдаанд ирүүлэх бүтээлийг нэг бол түүний дижитал хувилбарыг дараах хаягаар шуудангаар илгээнэ үү:

UNESCO Bangkok
APPEAL Unit
920 Sukhumvit Road, Prakanong, Klongtoey
Bangkok 10110, Thailand

Нэг бол электрон шуудангаар
gender.bgk@unesco.org илгээнэ үү.

Жич: дижитал хувилбараар илгээх бол TIFF, ESP, JPEG форматтай бөгөөд нягтрал нь 300 dpi ба түүнээс дээш байна.

Бүтээл хүлээн авах эцсийн хугацаа 2011 оны 8 дугаар сарын 1-ний өдөр

Сонгон шалгаруулалт

Сонгон шалгаруулалт 2 шаттай явагдна: эхний шатны шалгаруулалтыг Нэгдсэн Үндэстний “Охидын Боловсрол Санаачлага”-ын түнш байгууллагуудын дунд санал хураалт явуулна. Хоёр дахь шатны сонгон шалгаруулалтыг интернетээр нээлттэй зохион байгуулах бөгөөд энэ тухай нийтэд тухайн үеэд зарлах болно.

Шалгарсан бүтээлүүдийг 2011 оны 11 дүгээр сард зарлах болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:
gender.bgk@unesco.org бичнэ үү.

Drawing Contest 2011

“How does girls’ education help us all?”

Гар зургийн уралдаан 2011

“Охидын боловсрол та бидэнд хэрхэн их тустай вэ?”

БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Зураг тус нэг бүрт, оролцогч тус нэг бүрийн холбодох мэдээллийг [Англи хэл дээр](#) бөглөж ирүүлнэ:

Нэр (first name):

Овог (family name):

Нас (age):

Хүйс (sex):

Улс (country):

Шуудангийн хаяг:

(postal address)

.....

Э-шуудан:

(email address)

.....

Гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээл нэг бүрийн зохиогчийн нэр, нас болон оршин суух орныг нь дурьдсан байх болно. Ийнхүү дурьдсанаас өөр мэдээллийг нийтэд дэлгэхгүй.

Хүүхдийн гарын үсэг

Асран хамгаалагчийн /багш/ гарын үсэг